

1. Япон улсын Нагоя хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сэдэвчилсэн сургалтад төслийн ажилтан болон ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн оролцож байна



DPUB2 төслийн ажилтан Х. Мөнхтуул төслийн үйл ажиллагаа болон өөрийн ажлын талаар танилцуулж байна

ЖАЙКА нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Нагоя хотод Белиз, Этёп, Монгол, Шри-Ланк, Тажикстан, Зимбабве зэрэг хөгжиж буй орнуудын төр, ТББ-ын төлөөлүүдийг Япон улсын туршлагаас суралцах 21 хоногийн хөтөлбөрт хамруулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тус хөтөлбөрт оролцож байгаа 6 орны төлөөлөл өөрийн ажиллаж байгаа байгууллагын талаар танилцуулгыг бэлдэж танилцуулав. Дээрх зургаан улсаас хамгийн түрүүнд Монгол улс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийг эхлүүлсэн байгаагаараа онцлог юм. Тиймээс DPUB2 төслийн ажилтан Х.Мөнхтуул Монгол улсад хэрэгжүүлж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх

төслийн хүрээнд өнөөдрийг хүртэл хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ололт амжилт зэргийн талаар танилцуулав. Мөн ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн Х.Батчимэг өөрийн ажилладаг “Бид Чадна МН Нэгдэл” ТББ-ын үйл ажиллагааг бусад оролцогчиддоо танилцууллаа.

Оролцогчид, Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, үйл ажиллагаа хэрхэн уялдаа холбоотой явагддаг талаар өдөр бүр шинэ зүйлс суралцаж байна. Мөн тэд хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудаар зочлон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг хэрхэн дэмжиж ажилладаг талаар бодит байдалтай танилцан өдөр бүр шинэ зүйлс суралцаар байна.



ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн Х. Батчимэг “Бид Чадна МН Нэгдэл” ТББ-ын үйл ажиллагааг танилцуулав

Сургалт 2-р сарын 2-нд өндөрлөх бөгөөд хөтөлбөрөөс суралцсан зүйлсээ эх орондоо хэрэгжүүлэхээр нутгийн зүг хөдлөх болно. Монгол улсаас оролцож байгаа хоёр оролцогч маань шинэ мэдлэг, эрч хүчээр дүүрэн ирнэ гэдэгт итгэж байна.



ЖАЙКА-ын сургалтад оролцогчид



Чөлөөт цагаараа Нагоя хот

СЭДЭВ

1 Япон улсын Нагоя хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сэдэвчилсэн сургалтад төслийн ажилтан болон ААНБ-уудад нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн оролцож байна

2 ААНБ-д нөлөөлөх 7 дахь удаагийн сургалт зохион байгуулагдлаа

3 Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багшийн урьдчилсан сургалт зохион байгууллаа


2. ААНБ-д нөлөөлөх 7 дахь удаагийн сургалт зохион байгуулагдлаа

Төслийн зүгээс 1-р сарын 30-ны өдөр “ААНБ-д нөлөөлөх 7 дахь удаагийн сургалт”-ыг зохион байгууллаа. Тус сургалтанд ААНБ-ын төлөөлөл нийт 23 хүн оролцов.

Семинарыг нээж Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр сургалтын төвийн тэргүүн Л. Гэрэлцэцэг үг хэлэв. Нээлтийн дараа Төслийн зохицуулагч Чива Хисао DPUB2 төслийн талаар танилцуулга хийж, “Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудал” сэдвээр илтгэл тавив.

Мөн ААНБ-д нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн Г.Эрдэнэзул “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар, 4 саад-Тохирох хэрэглэгдэхүүн, түүнийг хэрхэн бүрдүүлэх тухай” сэдвээр, нөлөөллийн багийн гишүүн Д.Удвал “ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төрөөс үзүүлж буй дэмжлэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйл (ХБИ-ийн ажил олголтын квот, ажлын байрны төлбөр, урамшуулал)” сэдвээр тус тус илтгэл тавив.

Семинарын төгсгөлд, төслийн удирдагч Чива Хисао болон нөлөөллийн багийн гишүүд оролцогчдын саналыг сонсож, сонирхсон асуултанд нь хариулт өгөв.



Нөлөөллийн багийн гишүүн Д.Удвал

3. Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багшийн урьдчилсан сургалт зохион байгууллаа



8 сургагч багш хэлэлцүүлэг хийж байна

1-р сарын 30-аас 2-р сарын 1-ний өдрүүдэд ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багш нар, “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхдугаар сургалт”-ын бэлтгэл ажлын талаар ярилцсанаас гадна Япон дахь сургалтын урьдчилсан сургалтад хамрагдлаа.

1-р сарын 30, 31-ний өдрүүдэд төслийн дэд зөвлөх Исобэ Ёоко ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтын лекцийн гол агуулгуудыг нэгтгэн тайлбарлаж, ажлын байрны дадлагажуулагчийн үзэл баримтлал, гүйцэтгэх үүрэг, дэмжлэг үзүүлэх явцын талаарх ойлголтыг бататгав. Харин сургалтын сүүлчийн өдөр дүрд орж тоглох дасгал ажлын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд Монголын Аутизмын холбооны зөвлөх Л.Алтангэрэл чиглүүлэгчээр ажиллав.

Монгол улс дахь ажлын байрны дадлагажуулагч нар хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст дэмжлэг үзүүлэх тул олон талын ур чадварыг эзэмших шаардлагатай. Гиймээс сургагч багш нар 3-р сард зохион байгуулагдах ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтын үеэр ямар мэдлэг, ур чадварыг заах талаар идэвхтэй санал солилцлоо.

Эдгээр 8 сургагч багш 2-р сарын 8-аас Япон дахь сургалтад хамрагдах бөгөөд Японы ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтад ажиглагчаар оролцож, дасгал ажлын үеэр гүйцэтгэх сургагч багшийн үүрэг, чиглүүлэг хийх аргын талаар суралцана.

Харин 3-р сарын ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалтад найман сургагч багш нар өөрсдөө хичээл заах юм. Энэ удаагийн сургалтаар нийт 36 ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх төлөвлөгөөтэй байна.



Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багш

 dpub.jica@gmail.com

 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5

 <https://www.facebook.com/jicadpub1and2>

 <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

